**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2026/15/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Аудитор: Н.Хулансүрэн<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: Khulansurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 02.25 № 77

танай ____________ -ны №____________ -т

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.ЦЭНДСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд нийт 71 аж ахуйн нэгж, иргэний 1,737,144.7 мянган төгрөгийн 5,477.0 сая тонн бараа тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, 62,030,066.0 мянган төгрөгийн татвар, 7,979.0 мянган төгрөгийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлж ажиллахдаа нийт 1,715,187.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2025 оны 674 дугаар "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолын дагуу 112,500.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг биет бус хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

4526050246

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гаалийн ерөнхий газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 84.16 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **472,282,393.42** | **521,721,397.41** |
| **33** | **АВЛАГА** | **5** | **1,713,109.28** | **2,061,847.59** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 1,713,109.28 | 2,061,847.59 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | **429,130,854.00** | **483,130,854.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | 429,130,854.00 | 483,130,854.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **41,438,430.14** | **36,528,695.82** |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | 7,166,063.00 | 5,403,145.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | **34,272,367.14** | **31,125,550.82** |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 501,040.00 | 26,140.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 11,521,764.00 | 10,274,519.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 1,416,999.94 | 363,199.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 20,832,563.20 | 20,461,691.92 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,480,864,972.55** | **1,807,968,823.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **1,480,864,972.55** | **1,807,968,823.05** |
| **392** | **Биет хөрөнгө** | | **1,298,876,683.55** | **1,513,638,034.05** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 1,626,113,576.88 | 1,626,113,576.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (394,593,754.57) | (439,278,850.57) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 295,000,000.00 | 615,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (295,000,000.00) | (352,777,777.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 398,622,634.72 | 393,595,780.72 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (337,160,899.92) | (333,354,298.30) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 96,276,617.84 | 93,206,444.21 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (90,381,491.40) | (88,866,841.17) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | **181,988,289.00** | **294,330,789.00** |
| 39301 | Програм хангамж | | 25,924,189.00 | 33,424,439.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (4,335,900.00) | (11,993,650.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 167,900,250.00 | 272,900,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | (7,500,250.00) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **1,953,147,365.97** | **2,329,690,220.46** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9** | **-** | **955,479.58** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **-** | **955,479.58** |
| **413** | **Өглөг** | | **-** | **955,479.58** |
| **4136** | **Бусад өглөг** | | **-** | **955,479.58** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | | 955,479.58 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **1,953,147,365.97** | **2,328,734,740.88** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **1,953,147,365.97** | **2,328,734,740.88** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | | **1,613,637,373.08** | **1,613,637,373.08** |
| 51101 | Өмч: - төрийн | | 1,613,637,373.08 | 1,613,637,373.08 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | **(134,484,376.03)** | **241,102,998.88** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | (437,523,391.28) | (134,484,376.03) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 303,039,015.25 | 375,587,374.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 473,994,368.92 | 473,994,368.92 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **1,953,147,365.97** | **2,329,690,220.46** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **2,603,206,930.00** | **2,168,005,917.27** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **15,950,280.00** | **413,919,427.27** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | **15,950,280.00** | **413,919,427.27** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 12,948,000.00 | 412,762,947.27 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 12,948,000.00 | 412,762,947.27 |
| 120005 | Түрээсийн орлого | | 3,002,280.00 | 1,156,480.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **2,587,256,650.00** | **1,754,086,490.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **2,554,756,650.00** | **1,715,187,190.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 2,554,756,650.00 | 1,715,187,190.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **32,500,000.00** | **38,899,300.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 32,500,000.00 | 38,899,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **2,299,202,114.75** | **1,789,723,762.61** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,299,202,114.75** | **1,789,723,762.61** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **1,634,359,778.13** | **1,705,089,028.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **1,245,117,394.50** | **1,355,499,636.28** |
| 210101 | Үндсэн цалин | | 628,133,754.49 | 662,194,878.30 |
| 210102 | Нэмэгдэл | | 304,111,498.01 | 343,029,364.98 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 160,162,500.00 | 197,125,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 152,709,642.00 | 153,150,393.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **154,675,881.89** | **170,780,251.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 104,851,637.62 | 115,798,560.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 12,335,486.89 | 13,623,360.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 6,650,040.46 | 7,398,929.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 6,167,743.38 | 6,791,880.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 24,670,973.54 | 27,167,520.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **22,785,944.09** | **23,121,300.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 10,331,706.71 | 11,727,267.75 |
| 210302 | Түлш, халаалт | | 9,758,664.08 | 7,298,204.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 2,695,573.30 | 4,095,828.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **15,910,264.22** | **14,809,177.32** |
| 210401 | Бичиг хэрэг | | 3,727,330.00 | 3,151,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 7,946,399.94 | 7,420,600.04 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,046,434.28 | 1,723,711.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 330,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,799,100.00 | 1,342,845.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 61,000.00 | 990,871.28 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **5,670,581.36** | **10,503,429.00** |
| 210604 | Урсгал засвар | | 5,670,581.36 | 10,503,429.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **1,227,500.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,227,500.00 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **49,135,817.00** | **48,361,018.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 43,092,700.00 | 40,368,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 210,240.00 | 250,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 69,000.00 | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 330,000.00 | 1,430,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 351,000.00 | 400,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 2,582,877.00 | 3,313,018.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **139,836,395.07** | **82,014,217.02** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 122,500.00 | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 139,713,895.07 | 81,414,217.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **664,842,336.62** | **84,634,733.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **346,204,946.92** | **30,979,353.17** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 38,272,447.00 | 30,979,353.17 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 307,932,499.92 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **316,986,668.29** | **53,655,380.82** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 316,986,668.29 | 53,655,380.82 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | **1,650,721.41** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,650,721.41 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **304,004,815.25** | **378,282,154.66** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **965,800.00** | **2,694,779.75** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | | 2,441,779.75 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 965,800.00 | 253,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | **(965,800.00)** | **(2,694,779.75)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **303,039,015.25** | **375,587,374.91** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,590,258,930.00** | **1,755,242,970.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,002,280.00** | **1,156,480.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,002,280.00** | **1,156,480.00** |
| 120005 | Түрээсийн орлого | 3,002,280.00 | 1,156,480.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,587,256,650.00** | **1,754,086,490.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,554,756,650.00** | **1,715,187,190.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,554,756,650.00 | 1,715,187,190.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **32,500,000.00** | **38,899,300.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,500,000.00 | 38,899,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,590,258,930.00** | **1,755,242,970.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,590,258,930.00** | **1,755,242,970.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,925,416,593.38** | **1,670,608,236.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,245,928,993.26** | **1,357,077,096.72** |
| 210101 | Үндсэн цалин | 602,614,670.67 | 668,319,486.38 |
| 210102 | Нэмэгдэл | 330,215,004.48 | 341,865,955.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 160,357,614.49 | 194,573,501.04 |
| 210104 | Урамшуулал | 152,741,703.62 | 152,318,154.30 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **154,027,427.75** | **168,596,049.29** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 108,040,224.80 | 94,490,376.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,682,500.00 | 48,856,401.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,870,480.52 | 3,715,766.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,286,844.51 | 4,306,621.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,147,377.92 | 17,226,884.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,785,944.09** | **23,121,300.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,331,706.71 | 11,727,267.75 |
| 210302 | Түлш, халаалт | 9,758,664.08 | 7,298,204.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,695,573.30 | 4,095,828.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,067,234.28** | **12,064,861.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,908,300.00 | 2,748,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,933,400.00 | 6,366,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,046,434.28 | 1,723,711.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,849,100.00 | 1,045,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **437,834,054.00** | **64,970,929.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,893,900.00 | 620,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 254,500.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 434,685,654.00 | 64,350,929.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,227,500.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,227,500.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **47,422,940.00** | **44,178,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 43,092,700.00 | 40,368,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 210,240.00 | 250,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 69,000.00 | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,200,000.00 | 560,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 351,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **122,500.00** | **600,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 122,500.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **664,842,336.62** | **84,634,733.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **346,204,946.92** | **30,979,353.17** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,272,447.00 | 30,979,353.17 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 307,932,499.92 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **316,986,668.29** | **53,655,380.82** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 316,986,668.29 | 53,655,380.82 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,650,721.41** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,650,721.41 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 1,613,637,373.08 | 473,994,368.92 | (437,523,391.28) | - | 1,650,108,350.72 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,613,637,373.08** | **473,994,368.92** | **(437,523,391.28)** | **-** | **1,650,108,350.72** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний  бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 303,039,015.25 | - | 303,039,015.25 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,613,637,373.08** | **473,994,368.92** | **(134,484,376.03)** | **-** | **1,953,147,365.97** |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **1,613,637,373.08** | **473,994,368.92** | **(134,484,376.03)** | **-** | **1,953,147,365.97** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,613,637,373.08** | **473,994,368.92** | **(134,484,376.03)** | **-** | **1,953,147,365.97** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 375,587,374.91 | - | 375,587,374.91 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,613,637,373.08** | **473,994,368.92** | **241,102,998.88** | **-** | **2,328,734,740.88** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **ОРЛОГЫН ДҮН** | **1,840,183,500.00** | **1,662,688,289.18** | **(177,495,210.82)** | **90.4** |
| **1200** | **Татварын бус орлого** | **3,000,000.00** | **1,156,480.00** | **(1,843,520.00)** | **38.5** |
| 120005 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 3,000,000.00 | 1,156,480.00 | (1,843,520.00) | 38.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,837,183,500.00** | **1,661,531,809.18** | **(175,651,690.82)** | **90.4** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,837,183,500.00 | 1,661,531,809.18 | (175,651,690.82) | 90.4 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,840,183,500.00** | **1,662,688,289.18** | **(177,495,210.82)** | **90.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,840,183,500.00** | **1,662,688,289.18** | **(177,495,210.82)** | **90.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,808,412,000.00** | **1,631,708,936.01** | **(176,703,063.99)** | **90.2** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,385,455,900.00** | **1,323,032,396.72** | **(62,423,503.28)** | **95.5** |
| 210101 | Үндсэн цалин | 582,622,600.00 | 668,319,486.38 | 85,696,886.38 | 114.7 |
| 210102 | Нэмэгдэл | 432,307,800.00 | 307,821,255.00 | (124,486,545.00) | 71.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 214,666,700.00 | 194,573,501.04 | (20,093,198.96) | 90.6 |
| 210104 | Урамшуулал | 155,858,800.00 | 152,318,154.30 | (3,540,645.70) | 97.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **165,836,500.00** | **164,341,449.29** | **(1,495,050.71)** | **99.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,134,200.00 | 90,639,149.29 | (1,495,050.71) | 98.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 48,087,700.00 | 48,755,554.35 | 667,854.35 | 101.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,333,200.00 | 3,665,345.65 | (667,854.35) | 84.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,256,200.00 | 4,256,200.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,025,200.00 | 17,025,200.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **23,121,300.00** | **23,121,300.00** | **-** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,976,100.00 | 11,727,267.75 | (248,832.25) | 97.9 |
| 210302 | Түлш, халаалт | 6,956,200.00 | 7,298,204.25 | 342,004.25 | 104.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,189,000.00 | 4,095,828.00 | (93,172.00) | 97.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,573,000.00** | **12,064,861.00** | **(3,508,139.00)** | **77.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,987,200.00 | 2,748,750.00 | (1,238,450.00) | 68.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,600,200.00 | 6,366,800.00 | (233,400.00) | 96.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,194,900.00 | 1,723,711.00 | (471,189.00) | 78.5 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 399,000.00 | 180,000.00 | (219,000.00) | 45.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,391,700.00 | 1,045,600.00 | (1,346,100.00) | 43.7 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **173,619,900.00** | **64,970,929.00** | **(108,648,971.00)** | **37.4** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 620,000.00 | 620,000.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 497,900.00 | - | (497,900.00) | - |
| 210406 | Урсгал засвар | 172,502,000.00 | 64,350,929.00 | (108,151,071.00) | 37.3 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **44,629,400.00** | **44,178,000.00** | **(451,400.00)** | **99.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,781,100.00 | 40,368,000.00 | (413,100.00) | 99.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 250,000.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 100,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 598,300.00 | 560,000.00 | (38,300.00) | 93.6 |
| 210807 | Газрын төлбөр | 400,000.00 | 400,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **176,000.00** | **-** | **(176,000.00)** | **-** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 176,000.00 | - | (176,000.00) | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,771,500.00** | **30,979,353.17** | **(792,146.83)** | **97.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,771,500.00** | **30,979,353.17** | **(792,146.83)** | **97.5** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,771,500.00 | 30,979,353.17 | (792,146.83) | 97.5 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **37.00** | **33.00** | **(4.00)** | **89.2** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 24.00 | (2.00) | 92.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 8.00 | (2.00) | 80.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **1** | **ОРЛОГЫН ДҮН** | **38,899,300.00** |
| **13** | **Татаас, санхүүжилтийн орлого** | **38,899,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **38,899,300.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,899,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **38,899,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **38,899,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **38,299,300.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **34,044,700.00** |
| 210102 | Нэмэгдэл | 34,044,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,254,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,851,227.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 100,847.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 50,421.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 50,421.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 201,684.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **600,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 120,955.7 мянган төгрөгийн 3 алдааг[1] аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийн бусад хэсэгт программ хангамж, хуримтлагдсан элэгдлийг элэгдлийн хамт бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэснийг ангилал зөрүүлж тайлагнасныг программ хангамжийн хэсэгт бүртгэж залруулсан.
2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 674 дугаар тушаалаар Дархан-Уул аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс шилжүүлсэн 112,500.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг бүртэлд аваагүйг санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгийн дансанд нэмж тусгуулсан,
3. НДШ-ийн тайлан болон ХХОАТ-ын тайланг дутуу тайлагнаснаас НДШ-д 867.0 мянган төгрөг, ХХОАТ-т 88.5 мянган төгрөг, нийт 955.5 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүйг өглөгийн дансанд нэмж тусгуулсан.

Эдгээр нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 4.1, 4.2 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн *“Толилуулга”* батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайлангийн холбогдох үзүүлэлтүүдийг залруулав.

Мөн аудитаар илэрсэн 3,564.0 мянган төгрөгийн зөрчил[2]-д 1 зөвлөмж хүргүүлэв.

### 3.1 Зөвлөмж

*5.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд 3,564.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт зааснаар ёс зүйн дэд хорооны гишүүдэд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх.

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийн бусад хэсэгт 2ш программ хангамжийг элэгдлийн хамт дансны ангилал зөрүүлж бүртгэсэн байна. | 1 | 7,500.2 | - | - | 1 | 7,500.2 | 1 | 7,500.2 | - | - | - | - |
| Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 674 дугаартай "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" жагсаалтаар Дархан-Уул аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 112,500.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрхийг бүртгэлд аваагүй зөрчил илэрлээ. | 1 | 112,500.0 | 1 | 112,500.0 | - | - | 1 | 112,500.0 | | | | |
| Цалингийн зардлыг НДШ, ХХОАТ-ын тайланд бүрэн тайлагнасан эсэхийг давтан тооцоолоход НДШ-д 867.0 мянган төгрөг, ХХОАТ-т 88.5 мянган төгрөг, нийт 955.5 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүй байна. | 1 | 955.5 | 1 | 955.5 | - | - | 1 | 955.5 | | | | |
| **Дүн** | **3** | **120,955.7** | **2** | **113,455.5** | **1** | **7,500.2** | **3** | **120,955.7** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| **Зөрчлийн товч утга** | **Нийт зөрчил** | | **Үүнээс** | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцуулах албан шаардлага** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Албан тушаалтны тоо** | **Тоо** | **Дүн** |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгосон байна. | 1 | 3,564.0 | - | - | - | - | 1 | 3,564.0 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **3,564.0** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **3,564.0** | **-** | **-** | **-** | **-** |